

Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2022 оны жилийн эцсийн хэрэгжилт

2022.12.23

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	хувь
ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ										
121	6.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийг 2020 онд 238 байсныг 244 болгож нэмэгдүүлнэ.	6.1.1.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулна.	2021 - 2025		Улсын тусгай хамгаалалттай нутгийн хэмжээ	5.7	10.2	БХНСАХЗ 6.8	“Сүм хөх бүрд” аймгийн тусгай хамгаалалттай 548.5 га газрын талбайн хэмжээг нэмэгдүүлж 32588.17 га болгон улсын тусгай хамгаалалтад оруулахаар Адаацаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 37 дугаар тогтоол тус тус гаргуулж, албан бичгээр БОАЖЯаманд хүргүүлэв. Ингэснээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 5.7 хувиас 10.6 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүлж ажилласан.	100
122		6.1.1.2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх	2021 - 2025		орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, хувь	21.3	22.3		Хулд сумын Олдохын хийд, Дэрэн сумын Бумбатын овоо, Бумбатын шорвог, Тэгшийн суурин орчмын сумын тусгай хамгаалалттай газруудын тогтоолыг шинэчилж газар нутгийг өргөтгөн сумын ИТХурлаар батлав. Ингэснээр орон	100

		шийдвэр гаргуулна.							нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 21.8 хувиас 22.3 хувь болж нэмэгдэв.	
123		6.1.1.3. Аймгийн хэмжээнд амьтан, ургамлын нарийвчилсан тооллогыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн нөөцийг тогтооно.	2021 - 2025		судалгаа хийлгэсэн тоо	-	-		аймгийн агнуур зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 5 жил 1 удаа хийдэг. Тус судалгааг 2017 онд хийлгэж 2022 оноор дуусгавар болсон. 2023 онд шинээр судалгааг хийлгэж ажиллахаар төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	0
124	6.2.1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувийг 2020 онд 8.3 байсныг 2025 онд 21.7 хувиар нэмэгдүүлнэ.	6.2.1.1. Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 100 га-д хийлгэнэ.	2021 - 2025		Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ га	79.64	104.6	Хувийн хэвшил 110.4	Нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, эвдэрсэн газрыг бууруулах зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт 6 сумын нутаг дэвсгэрт 9 талбар бүхий газарт 7.77 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн. Үүнд: Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газарт 5.31 га, хайгуулын улмаас эвдэрсэн талбайд 0.12 га, эзэнгүй эвдэрсэн газарт 2.3 талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийгдэж нийт нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ 121.02 га-д хүрсэн.	100

125		6.2.1.2. Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 25 га-д хийлгэнэ.	2021 - 2025		Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ (га)	1	16	Хувийн хэвшил 12.0	Тус аймгийн 4 сумын нутаг дэвсгэрт 5 аж ахуйн нэгж 4.2 га талбайд мод бут, олон наст ургамал тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн, мөн эзэнгүй эвдэрсэн газрын тооллогын дүнг өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад Дэлгэрцогт сумын 14.54 га газар байгалийн аясаар ургамалжин нөхөн сэргээгдсэн үзүүлэлт гарсан. Нийт биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай 24.74 га-д хүрсэн.	100
126	6.2.2. Ногоон байгууламжийн	6.2.2.1. Төв зам дагуу ногоон байгууламжийг бий болгоно.	2021 - 2025		Ногоон байгууламжийн хэмжээ (га)	0	10	ОНТ 5.5	Худалдааны гудамжны тохижилтын зураг төсвийг “Чанс” ХХК гүйцэтгэж зургийн дагуу Хот тохижуулах газар 96 хайрцагт 558 бортоготой мод тарьж хотын өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүллээ. Төв зам дагуух ногоон байгууламжийн хэмжээ нийт 25.9 га-д хүрэв.	100
127	хэмжээ 2020 онд 369.4 га байгааг 2025 онд 414.4 га-д хүргэнэ.	6.2.2.2. Аймгийн хэмжээнд 4 га талбайд ойн зурвас байгуулна.	2021 - 2025		тухайн жилд байгуулсан ойн зурвасын талбайн хэмжээ (га)	5	1	УТ, ОНТ 102.5	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Өлзийт суманд 2 га, Дэлгэрхангай суманд 2 га, Говь-Угтаал суманд 1 га нийт 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгэж аймгийн Засаг даргын А/382 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авлаа. “Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх” хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэдалай суманд 8 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг	100

									“Тэнгэрлэг ой” ХХК гүйцэтгэж аймгийн ЗДТГазрын даргын А/240 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авлаа.	
128	6.2.3. Зэрлэг амьтдын нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөцийг хамгаалах арга хэмжээний тоо 2020 онд 11 байсныг 2025 онд 42 болгож нэмэгдүүлнэ.	6.2.3.1. Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, биотехникийн арга хэмжээ авна.	2021 - 2025		Биотехникийн арга хэмжээ авсан давтамж	27	30		Тус аймгийн 8 сум, улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 4 газар, 6 агнуурын бүсэд 37 удаагийн давтамжтай 511 боодол өвс, 12 тонн хужир, мараа тавьж зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авсан. Тусгай хамгаалалттай 8 газарт зэрлэг амьтан ажиглах камер байрлуулж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн байдал, хууль бус ан зэргийг хянах боломжтой болов. Мөн Сайхан-Овоо сумын агнуурын бүс гандуу, хуурайшилтай байсан тул зэрлэг амьтдын хорогдлоос сэргийлж шинээр 1 уст цэг, Өлзийт сумын Хөтлийн усанд шинээр 1 уст цэг нийт 2 уст цэг байгуулсан.	100
129		6.2.3.2. Тарвага нутагшуулах ажлыг зохион байгуулна.	2021 - 2025		шинээр тарвага нутагшуулсан тоо	33	50	хувийн хэвшил 30	2022 оны 06 дугаар сарын 19-ны өдөр Их газрын чулууны ууланд Хустайн байгалийн цогцолборт газраас 50 толгой монгол тарвага авчирч нутагшууллаа. Тарвага сэргээн нутагшуулснаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хөрсний доройтол, цөлжилтийг сааруулах /хөрсний агаарын солилцоог хангаж,	100

									ургамалжилт болон ургамал нөхөн сэргэхэд чухал үүрэгтэй/ гэх мэт маш чухал ач холбогдолтой юм.	
130	6.3.1. Гадаргын усан хангамж 2020 онд 53 байсныг 2025 онд 175 болгон нэмэгдүүлж, хомсдолоос хамгаална.	6.3.1.1. Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэмдэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулна.	2021 - 2025		Хамгаалалтын бүс тогтоосон булгийн тоо	-	30	БХНСАХЗ 4.8	Тус аймгийн хэмжээнд усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор 160 булаг, нуур тойромд 40909,29 га усны сан бүхий газар нутгийг аймгийн ИТХурлын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 27 тоот тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Дэлгэрхангай, Баянжаргалан, Сайнцагаан, сумдын нутагт усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд 37 тэмдэг, тэмдэглэгээг байршуулав.	100
131		6.3.1.2. Булаг шанд, усыг түшиглэн хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулна.	2021 - 2025		Шинээр байгуулсан хөв цөөрмийн тоо	0	2	УТ 19.0 Хувийн хэвшил 3.0	Өлзийт сумын Буянт багийн нутаг "Жавхлант хайрхан" хэмээх газарт байрлах "Хөтөл ус"-ны энгийн уурхайн худгийг түшиглэн Улсын төсвийн хөрөнгөөр хөв цөөрөм байгууллаа. Зураг төсвийн дагуу 1000 мм голчтой 3 ширхэг кольцо суулган, 120 мм диаметртэй 42 метрийн урт ус дамжуулах хоолой суурилуулж, 4 м ³ эзлэхүүнтэй усан сан хийж гүйцэтгэлээ. Мөн Юнител группийн хөрөнгө оруулалтаар "Дэлгэрхангай уул", "Их газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газруудад зэрлэг амьтдад зориулсан хөв цөөрмийг байгуулав.	100

132		6.3.1.3. Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулна.	2021 - 2025		Хашсан булгийн тоо	53	59	БХНСАХЗ 15.0	Луус сумын “Зодохын булаг”, Хулд сумын “Жирмийн булаг”, Сайхан-Овоо сумын “Жарантайн булаг”-ийн эхийг хашин хамгаалж газрын даргын А/20 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг актаар хүлээн авлаа. Тус булгуудыг хашиж хамгаалснаар 16 өрхийн бог, бод нийлсэн 10655 мал ундаална. Нийт 59 булгийн эхийг хашиж хамгаалаад байна.	100
133	6.4.1. Аймгийн төвд хог хаягдлыг ангилах ажлыг	6.4.1.1. Ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлнэ.	2021 - 2025		Хогийн савны нэмэгдүүлсэн тоо	25	35	ОНТ 22.1 Хувийн хэвшил 19.0	Аймгийн хэмжээнд нийт 21 ширхэг ангилан ялгах хогийн сав шинээр бий болсноос аймгийн төвд 9 ААН, байгууллага ангилан ялгах хогийн сав байршуулж нийт Сайнцагаан суманд 41 болж нэмэгдэв.	100
134	эхлүүлж, хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт 2025 он гэхэд нийт хог хаягдлын 0.022 хувийг нийлүүлнэ.	6.4.1.2. Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, эрүүлжүүлнэ.	2021 - 2025		Шууж булшилсан талбайн хэмжээ (га)	7,4	12	ОНТ 65.2	Хог хаягдлын төвлөрсөн цэгийн тохижилтын ажил Хулд суманд 0.2 га, Дэлгэрцогт суманд 0.2 га, Эрдэнэдалай суманд 7 га, Адаацаг суманд 1.5 га, Сайнцагаан суманд 4 га нийт 12.9 га газрыг шууж, булшлах ажил хийгдсэн.	100
136		6.4.1.4. Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд шинэ	2021 - 2025		Технологи нэвтрүүлсэн төслийн тоо	1	1	УТ 608.5	Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд шахмал түлшний үйлдвэрлэл нэвтрүүлэх ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон тул аймгийн төвийн том оврын уурын	100

		дэвшилтэд техник, технологи /шахмал түлшний үйлдвэр/ нэвтрүүлэх аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.							зуухнуудын янданд утаа шүүгч төхөөрөмж байршуулахаар төлөвлөн БОАЖЯамнаас санхүүжүүлэн “Регал инженеринг” ХХК-тай гэрээ байгуулсны дагуу “Дундговь –Ус” ОНӨҮГ-ын 2 дугаар зууханд 3, “Тэвшийнговь” ХХК-ийн 1 дүгээр зууханд 1, “Ган-Илч” ХХК-ийн 1 дүгээр зууханд 4, нийт төвлөрсөн халаалтын 8 янданд утаа шүүгч байршуулах ажил хийгдсэн. Улсын төсвийн 608.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.	
НАЙМ. БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ										
163	8.2.1. Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой эвент арга хэмжээ 2019 онд 4 байсныг 2025 онд 9-өөр нэмэгдүүлнэ.	8.2.1.1. Жуулчдын голлон зорих байгаль, түүх, соёлын өв бүхий Дэл уул зэрэг газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулна.	2021 - 2025		Тухайн жилд байгуулах отоглох цэгийн тоо	1	1	УТ 197.2	Тус аймгийн Гурвансайхан сумын Их газрын чулуу, Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт 2 газарт “Отоглох цэг” байгуулсан. Отоглох цэгт 1,2 га талбайн хамгаалалтын хашаа, Машины зогсоол 40, Майхан барих талбай 31, Ариун цэврийн байгууламж 24 мкв байр, септик танктай, Шингээлгийн талбай 36 мкв, ОО 5, Угаалтуур 2, Ус нөөцлөх сав 2, Явган зам 120 м, Гэрэлтүүлэг 8, Сүүдрэвч 2, Ширээ, сандал 4, Гал түлэх цэг 2, Шорлогны зуух 2, Угтах хаалга, Мэдээллийн самбар 2, Тэмдэг, тэмдэглэгээ 13, Тэмээн зэл 1 ширхгийг хийсэн. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2022 оны Дугаар 21/2022 үүрэг	100

									даалгаврын биелэлт, актаар хүлээж авсан.	
164		8.2.1.2. Сүм хөх бүрд зэрэг аялал жуулчлалын гол бүс нутгуудад орон нутгийн өмчийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих замаар үйлчилгээний чанарын стандартыг дээшлүүлнэ.	2021 - 2025		ААНэгжид үзүүлсэн дэмжлэгийн тоо	-	1	УТ 999.2	Сүм хөх бүрдэд 2 цомцог гэр, шилэн нүүр бүхий 150 хүний багтаамжтай асар, гэрэлтүүлэг, зөөврийн шилэн тайз зэрэг хөрөнгө оруулалтыг БОАЖЯамнаас “Ижий говь” төслийн хүрэнд нийлүүлснээр 8 ор хоног нэмэгдэж хүчин чадал, үйлчилгээний чанарын стандарт сайжирсан. Тус төслийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 сарын 17-ны өдрийн дугаар 03 актаар хүлээж авсан.	100
165		8.2.1.3. Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр нэгдсэн зохион байгуулалттай оролцож, /хятад, солонгос, англи зэрэг хэл дээр видео контентууд хийж/ орон нутгаа сурталчилна.	2021 - 2025		Гадаад жуулчдыг хүлээн авах байгуулсан гэрээний тоо	100	200	БХНСАХ32.0 Хувийн хэвшил 2.1	Монголын Аялал Жуулчлалын Холбоо” ТББ-аас "Аялал жуулчлал – Бизнес хэлцэл” үйл ажиллагаанд 200 тур оператор компанийн төлөөлөл оролцсон бөгөөд Дундговь аймгаас “Цагаан суварга”, “Говь каравансерай”, “Эрдэнэ-Ухаа”, “Бага газрын чулуу”, “Онгийн нууц” гэсэн 5 жуулчны бааз оролцож тур оператор компаниудтай 2022 онд жуулчин авах гэрээ 223 байгуулсан. ITM 2022 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Говийн шуранхай АЖхолбоо, Цагаан суварга, Эрдэнэ-Ухаа, Баянбулаг, Онги-Энержи, Бага газрын чулуу, Говь хулан, Онгийн нууц жуулчны баазууд, Сүм хөх бүрд,	100

									Ачлал-Оргил амралтын газар гэсэн 9 аж ахуйн нэгж байгууллага нэгдсэн зохион байгуулалттай оролцож, тур оператор компаниудтай 2023 онд жуулчин хүлээн авах 257 гэрээ байгуулж, 2100 тараах материал тарааж ажиллалаа	
Нийт дүн: 18 арга хэмжээ: 17*100%, 1*0%										94.4%

ХЯНАСАН:

ДАРГА

Н.ГАНТУЛГА

ТАЙЛАН ГАРГАСАН

МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТХҮҮ